

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот  
2023 он**

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

**Гарчиг**

**Нэг. Ерөнхий зүйл**

**Хоёр. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал**

**Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал**

**Дөрөв. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал**

- 4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ
- 4.2. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ
- 4.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ
- 4.4. “Харилцан уялдааг шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

**Тав. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал**

- 5.1. Зөвлөмж
- 5.2. Дүгнэлт
- 5.3. Баримтжуулалт

# НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН

## Нэг. Ерөнхий зүйл

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг Эрүүл мэндийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан эсэхийг нягталж, хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ямар үр дагавар, үр нөлөө үзүүлэхийг тооцох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, салбарын бусад хууль тогтоомжийн харилцан уялдааг тогтоох, хуулийн төслийг ойлгомжтой, хүлээн зөвшөөрөгдөх, практикт хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу үр нөлөөний үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт заасныг баримтлан Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-д нийцүүлэн “анхдагч хуулийн төсөл” хувилбарыг сонгон авч, боловсруулсан байна.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг дараах үе шаттайгаар зохион байгуулав:

- шалгуур үзүүлэлтийг сонгох;
- хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох;
- шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

### Хоёр. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгосон:

- зорилгод хүрэх байдал;
- ойлгомжтой байдал;
- хүлээн зөвшөөрөгдөх байдал;
- харилцан уялдаа.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль нь “анхдагч хуулийн төсөл” тул **“зорилгод хүрэх байдал”** шалгуур үзүүлэлтийг сонгон авч, дараах 3 шалгах хэрэгслээр тодорхойлж үзэв:

1. Хуулийн төсөлд туссан зүйлүүд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэж чадах эсэх;
2. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх;
3. Хуулийн төслөөр дэвшүүлсэн зорилгод хүрч чадах эсэх.

**“Ойлгомжтой байдал”** шалгуур үзүүлэлтийн тухайд дараах 3 шалгах хэрэгслээр тодорхойлов:

1. Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъект буюу нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртэгч иргэд, олон нийт, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, албан хаагч, эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллага, аж ахуйн нэгжийн хувьд ойлгомжтой эсэх;
2. Хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай эсэх;
3. Агуулга, хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой, тодорхой эсэх.

**“Хүлээн зөвшөөрөгдөх байдал”** шалгуур үзүүлэлтийн тухайд хуулийн үр дагаварт шууд хамаарах субъект (нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний хэмжээний байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нийгмийн эрүүл мэндийн нэгж, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургууль, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн үүсгэл санаачилгын байгууллага, аж ахуйн нэгж, сайн дурын ажилтан, иргэд) уг хуулийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх зорилгоор сонголоо.

**“Харилцан уялдаа”** шалгуур үзүүлэлтийн хувьд хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой нийцэж байгаа эсхүл зөрчилдөж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх шаардлагатай гэж үзэн тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

#### **Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал**

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо (Хүснэгт 1):

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1-4 дүгээр бүлэг	Хуулийн төсөлд дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдож чадсан эсэх болон хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах
2.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах	“Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын 2 дугаар бүлэгт заасан хуулийн төсөл боловсруулахад тавигдах нийтлэг шаардлага болон 3 дугаар бүлэгт нийцсэн эсэхийг шалгах
3.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах	Хуулийг хэрэгжүүлэх байгууллага (Монгол Улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яам, нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний хэмжээний байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв) болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдагч иргэн хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах
4.	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь хамруулах	“Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-т заасан хуулийн төслийн уялдаа холбоог шалгах хэрэгслийн хүрээнд тавигдах шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах

**Дөрөв. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал**

Энэ тайлангийн 3 дугаар бүлэгт сонгосон хэсгүүдэд шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах байдлаар үнэлгээ хийлээ:

**4.1. “Зорилгод хүрэх байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Эрүүл мэндийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ гэсэн 2 төрөлтэй болохыг, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.2-т нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгох, улмаар хүн амын эрүүл мэндийн талаар төрөөс

баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхээр тодорхойлжээ.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо, төрөл, зохион байгуулалт болон санхүүжилтийг 2016 онд батлагдсан Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар зохицуулж ирсэн бол нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо, төрөл, зохион байгуулалт болон санхүүжилтийн асуудлыг орхигдуулсан байна. Түүнчлэн эрүүл мэндийн салбарын нийт ажиллагсдын 1.9 хувь нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн байгаа нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ хэт давамгайлсан, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орхигдуулсныг харуулж байна. Үүнээс үзэхэд хүн амын бүлэгт чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ дутагдалтай байна. Жишээлбэл, 2022 онд 45,705 иргэн цэрэг татлагаар эрүүл мэндийн үзлэгт хамрагдахад 15,082 иргэн буюу 3 хүн тутмын 1 нь эрүүл мэндийн байдлаар цэргийн албанд тэнцээгүй байна.

Гэтэл Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хүний аюулгүй байдлыг бүрэлдэхүүн хэсэгт хамааруулж, эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 3.4.1.1-д “Нийгмийн эрүүл мэндийн салбарын хөгжлийг дэмжиж, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлыг бүх шатны боловсролын байгууллага, хэвлэл мэдээллээр дамжуулан хэрэгжүүлнэ” гэж заасан нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үндэсний хэмжээнд авч үзэх шаардлагатай болсныг харуулжээ.

Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 151-д Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг Эрүүл мэндийн яам хариуцан боловсруулж, Засгийн газар 2022 онд өргөн барихаар, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.5-д Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг батлуулахаар тус тус заажээ. Мөн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх “I үе шат буюу 2021-2030 онд эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн хүрээнд “иргэн, гэр бүл, ажил олгогчийн оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо бэхэжсэн байна”, “Аймаг, дүүргийн түвшинд хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулна” гэж, 2.2.10-т “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх” арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгажээ.

Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр 2022 онд хийгдсэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд нийт 781,765 хүн хамрагдсан бөгөөд уг үзлэгийн дүнгээр иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс илүүтэй нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох, хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор хүн амыг өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэхэд бүх нийтийн анхаарлыг чиглүүлэх боломж бүрдэнэ гэж үзжээ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийн “зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар үнэлэв (Хүснэгт 2):

Хүснэгт 2

Д/д	Шалгуур үзүүлэлт, шалгах хэрэгсэл	Хуулийн төсөлд тусгасан зохицуулалт, арга хэмжээ	Төслийн зүйл, заалт
1.	<p style="text-align: center;"><b>Зорилгод хүрэх байдал</b></p> <p>Хуулийн төсөлд туссан зүйл, заалтууд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэж чадах эсэх</p>	<p>Хуулийн төслийн 1.1-д хуулийн зорилтыг “хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулах”-аар тодорхойлжээ. Хуулийн төсөлд хүн амыг өвдөхөөс өмнө урьдчилан сэргийлэх, хүний эрүүл мэндэд нөлөөлөх эерэг болон сөрөг нөлөөллийг судлах, хүн, байгаль, нийгмийн зохицлыг хангаснаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдрах орчин бүрдүүлэх чиглэлээр хувь хүн, хамт олон, байгууллага, нийгмийн эрүүл мэндийн байгууллага, ажилтнууд хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан байна. Энэ нь хүн амын эрүүл мэндийн байдалд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх нөхцөл, бололцоог бүрдүүлэх боломжтой гэж үзлээ.</p>	<p>5.3.1-5.3.5, 7.2.3, 7.2.4, 7.3.5, 7.3.6, 7.3.8, 7.5.2, 7.5.5, 6.11.2, 6.11.4, 6.11.5, 10.1.2, 10.1.4, 11.1.2- 11.1.4,</p>
2.	<p>Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, түүний талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны тухай нарийвчилсан зохицуулалт оруулсан, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, төрийн болон иргэн, хуулийн этгээдийн эрх үүрэг, тэдгээрийн хоорондын хамтын ажиллагааны талаар нарийвчилсан зохицуулалтыг тусгасан байна.</li> <li>- Нийгмийн эрүүл мэндийн талаарх ойлголт, мэдлэгийг нийтэд хүргэх, хүн амыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий амьдралын зөв хэв маяг, дадалтай болгох талаар хуулийн төсөлд тусгасан байна.</li> </ul>	<p>5.2.1-5.2.7, 6.1-6.11, 7.1.1-7.1.5, 6.7-6.11, 9.1.1-9.1.3, 9.2.1-9.2.5, 10.1.1- 10.1.7, 11.1.1- 11.1.4, 12.3, 13.1.1, 5.2.4,</p>

3.		Хуулийн төслөөр дэвшүүлсэн зорилгод хүрч чадах эсэх	<ul style="list-style-type: none"> <li>- “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цар хүрээ, хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, бусад салбарын оролцоо тодорхой болж, Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эрүүл мэндийн салбарын тэргүүлэх чиглэл болон хөгжинө.</li> <li>- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үндэсний тогтолцоо бий болсноор Монгол Улсын хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болох халдварт, халдварт бус өвчлөл бодитоор буурч, цаашид гарах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх хууль, эрх зүйн зохицуулалттай болно.</li> <li>- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт тодорхой болж, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд зарцуулах зардлыг бууруулснаар эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн оновчтой хуваарилалт хийгдэх нөхцөл бүрдэнэ.</li> <li>- Иргэн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндээ хамгаалах насан туршийн боловсрол олгосноор өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэхэд бүх нийтийг хамруулах зорилт биелэх боломжтой болно.” гэж үзжээ.</li> </ul>	<p>6.1- 6.11, 7.1.1-7.1.5, 8.1-8.9, 9.1.1-9.1.5, 10.1.1- 10.1.7 11.1.1- 11.1.4, 13.1-13.5, 15.1-15.4, 14.1,</p>
----	--	---	--	---

Хуулийн төслөөр дэвшүүлсэн зорилгод хүрч чадах эсэхийг шалгах хэрэгслийг дараах байдлаар үнэлэв (Хүснэгт 3):

Хүснэгт 3

Д/д	Хуулийн төслийн зорилт	Хуулийн төслийн зүйл, заалт
1.	Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах	Хуулийн төслийн 3.1.6-д “тандалт” гэсэн нэр томъёог оруулснаас гадна төслийн 5.3.1, 8.2.7-д тусгасан байна.
2.	Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх	Хуулийн төслийн 3.1.4-т “эрүүл мэндийг дэмжих” гэсэн нэр томъёог оруулснаас гадна нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөлд багтаажээ. Хуулийн

		төслийн 6.10, 6.11.4, 8.2.5, 9.2.4, 10.1.2, 10.1.4-т тусгажээ.
3.	Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох	Хуулийн төслийн 3.1.13-т “эрүүл мэндийг боловсрол” гэсэн нэр томъёог оруулснаас гадна нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөлд багтаажээ. Мөн хуулийн төслийн 6.6, 8.1.4, 8.2.8, 8.4.2, 13.2.2-т тусгасан байна.
4.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг 7.1 дэх хэсэгт, тусламж, үйлчилгээний санхүүжилтийг 6 дугаар бүлэгт, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих харилцааг 6.3, 9.1.5-д, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг 17.1, 17.2 дахь хэсэгт тус тус тусгасан байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлохдоо нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төрөөс үзүүлэхэд зайлшгүй баримтлах зарчмыг оновчтой тодорхойлсон байна. Тухайлбал нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ил тод, тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх, шинжлэх ухааны нотолгоонд суурилсан байх, төр, иргэн, хуулийн этгээдийн хамтын ажиллагаанд тулгуурлах, үндэсний онцлог, уламжлалд суурилан олон улсын жишиг, хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх, ялгаварлан гадуурхалтаас ангид, хүний эрхийг дээдлэх, олон нийтийн оролцоо, сайн дурын ажилтны хувь нэмрийг чухалчлах гэжээ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрлийг халдварт болон халдварт бус өвчний хяналт, орчин, хөдөлмөрийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, шим судлал, нийгэм, сэтгэл зүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийн лаборатори, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээ зэрэг 7 чиглэл тус бүрээр ангилан Эрүүл мэндийн тухай хуулийн 13.2 дахь хэсэгт заасантай нийцүүлж тодорхойлсон нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүргийг тодорхойлох зорилтыг хангахад ач холбогдолтой болсон байна.

Хуулийн төслийн 7.1 дэх хэсэгт нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх байгууллагыг тодорхойлж, 8.1.1 дэх хэсэгт нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төв байгууллага, 8.2 дахь хэсэгт аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, 8.3 дахь хэсэгт эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн нэгж, алба, 8.4 дэх хэсэгт өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн чиг үүргийг тодорхойлж, удирдагын тогтолцоо нь хамтын удирдлага, төрийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, олон нийтийн оролцооноос бүрдэхээр тусгажээ.

Хуулийн төслийн үзэл баримтлалд туссан зорилгод тулгуурлан боловсруулсан хуулийн төслийн зохицуулалт бүрт дүн шинжилгээ хийхэд тухайн зохицуулалт, арга хэмжээ нь зорилгод хүрэх боломжтой гэж дүгнэлээ.

#### 4.2. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын хуулийн төсөл боловсруулахад тавигдах нийтлэг шаардлагыг дараах байдлаар үнэлэв (Хүснэгт 4):

Хүснэгт 4

<b>Хуулийн төслийн эх бичвэрийн асуулгад тавигдах шаардлага</b>		
1.	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Шаардлагыг хангасан.
2.	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх	Шаардлагыг хангасан.
3.	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харлцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх	Шаардлагыг хангасан.
4.	Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Шаардлагыг хангасан.
5.	Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх	Шаардлагыг хангасан.
<b>Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах шаардлага</b>		
6.	Хуулийн төслийн үг хэллэг, өгүүлбэрийг хэл зүй, найруулга, өгүүлбэр зүйн монгол хэл, бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй, товч тодорхой, ойлгоход хялбар байх	Шаардлагыг хангасан.
7.	Бичвэр нь үндсэн агуулгаас хоёрдогч ач холбогдол бүхий ерөнхийгөөс тусгай руу, нийтлэг журмаас тусгай руу гэсэн хэлбэртэй байх	Шаардлагыг хангасан.
<b>Хуулийн төслийн эх бичвэрт хэрэглэх арга, аргачлал</b>		
8.	1.Нэр томьёо хэрэглэх 2.Хуулийн төслийн үг хэллэг сонгох 3.Товчлол хийх 4.Ишлэл хийх	Шаардлагыг хангасан.
<b>Хуулийн төслийн эх бичвэрийг боловсруулахад тавигдах шаардлага</b>		
9.	Хуулийн төслийн эх бичвэрийг боловсруулахад холбогдох эрх зүйн баримт бичгийг баримталсан эсэх	Хуулийн төслийг боловсруулахад Хууль тогтоомжийн

	<p>тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг тус тус баримталсан байна.</p>
--	--

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр, 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгасан болно (Хүснэгт 5):

Хүснэгт 5

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр</b>	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
<p>28.1.Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна:</p> <p>28.1.1.хуулийн төслийн гарчиг;</p> <p>28.1.2.хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл;</p> <p>28.1.3.зүйлийн доторх хэсэг;</p> <p>28.1.4.хэсгийн доторх заалт;</p> <p>28.1.5.заалтын доторх дэд заалт;</p> <p>28.1.6.шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг, анги.</p>	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дугаар зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулга</b>	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал

29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Захиргааны хэрэг

	шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай дагалдах хуулийн төслүүдийг боловсруулсан байна.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Энэ талаар “зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дэлгэрэнгүй бичсэн болно.
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

#### **4.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

“Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 2.6-д заасныг баримтлан “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг буюу тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжид шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг дараах байдлаар шалгав.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх субъект нь хуулийн төслийн 7.1 дэх хэсэгт заасан байгууллага байх бөгөөд тусламж, үйлчилгээг иргэд, олон нийтэд чиглүүлэхээр тусгажээ.

Хуулийн төсөлд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдлагын тогтолцоог хамтын удирдлага, төрийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, олон нийтийн оролцооноос бүрдэхээр заасан. Үүний хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн захиргааны төв байгууллагууд, Эрүүл мэндийн яам, нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төв байгууллага, орон нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагаас нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр гүйцэтгэх чиг үүргийг тусгасан байна.

Мөн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төв байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нийгмийн эрүүл мэндийн нэгж, алба, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн үүсгэл санаачилгын байгууллага, аж ахуйн нэгжийн чиг үүрэг, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд сайн дурын ажилтан, иргэд, олон нийтийн үзүүлэх оролцоо, үүргийг тодорхойлсон байна.

Хуулийн төслийг хэрэгжүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага, төрийн бус байгууллага, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж байгаа ажилтнууд, аймаг, нийслэл, дүүргийн Эрүүл мэндийн газар, нийгмийн эрүүл мэндийн төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш, эрдэмтэн, судлаач, доктор, ахмад ажилтан, эрдэмтэд, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан, гүйцэтгэх албан тушаалтнууд оролцсон 18 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцогчдын саналыг нэгтгэжээ.

Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, төрийн бус байгууллага, бусад салбар, иргэний төлөөллийг оролцуулж, саналыг тухай бүрт тусгахын зэрэгцээ хуулийн төслийг эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд танилцуулж, бүх аймгийн Засаг даргын Тамгын газрын тухайн асуудлыг хариуцсан ажилтан, холбогдох бусад мэргэжилтнийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулжээ.

Хуулийн төслийг Эрүүл мэндийн яамны болон Улсын Их Хурлын Тамгын газрын цахим хуудсанд байрлуулж иргэд, олон нийт, сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургууль, аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нийгмийн эрүүл мэндийн нэгжээс ирүүлсэн саналыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нэгтгэн хуулийн төсөлд тусгажээ.

#### **4.4. “Харилцан уялдааг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

“Харилцан уялдааг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн уялдаа, холбоо хангагдсан эсэхийг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-т заасан 16 асуулт тус бүрд хариулах замаар шалган тогтоолоо (Хүснэгт 6):

Хүснэгт 6

Д/д	Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
1.	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн зорилгод хүрэх байдал хэсэгт дэлгэрэнгүй бичсэн болно.
2.	Хуулийн төслийн “хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Хууль тогтоомж гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр нь тухайн харилцаанд хамаарах хууль байна.
3.	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
4.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	<p>1. Хуулийн төслийн 6.5 дахь хэсэгт Засгийн газрын чиг үүргийг заахдаа зөвхөн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хэрэгжүүлэхтэй холбогдуулан үүсэх харилцааг тусгажээ. Мөн төслийн 6.7-6.8 дахь хэсэгт Эрүүл мэндийн яам нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах, бодлого, хөгжлийн чиг хандлага, хүний нөөц, тоног төхөөрөмж, технологийн хэрэгцээг тодорхойлох, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцооны горимоор ажиллаж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан байх тул нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой Засгийн газрын бүрэн эрхийг нэмж тодруулах нь зүйтэй.</p> <p>2. Эрүүл мэндийн тухай хуулийн 13.2 дахь хэсэгт “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүн амын эрүүл мэндийн</p>

		байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна.” гэж заасан тул төслийн 5.3 дахь хэсэгт хүн амын эрүүл мэндийн байдалд нөлөөлөх хүчин зүйлийг судлах, хянах чиглэлийг мөн нэмж тусгах шаардлагатай.
5.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үр нөлөөний үнэлгээгээр энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
6.	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.
7.	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	<p>1. Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ” гэдгийг Эрүүл мэндийн тухай хуулийн 13.2 дахь хэсэгт зааснаар “хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа” гэж өргөн хүрээнд тодорхойлсон хэрнээ төслийн 10.1 дэх хэсэгт аж ахуйн нэгж, байгууллагын чиг үүргийг тодорхойлохдоо “нийгмийн эрүүл мэндийг хамгаалах ...” гэж заасан нь нийгмийн эрүүл мэндийн талаарх бусад тусламж, үйлчилгээ орхигдоход хүргэхээр байна. Өөрөөр хэлбэл, төслийн 10.1 дэх хэсэгт заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн гүйцэтгэх нийтлэг чиг үүргийг нэмж зохицуулах нь зүйтэй.</p> <p>2. Хуулийн төслийн 7.1 дэх хэсэгт “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төв байгууллага, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр</p>

		сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургууль, аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нийгмийн эрүүл мэндийн нэгж, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн үүсгэл санаачилгын байгууллага, аж ахуйн нэгж, сайн дурын ажилтан үзүүлнэ.” гэж, төслийн 8.1 дахь хэсэгт нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төв байгууллагын чиг үүргийг заасан боловч эрүүл мэндийн бусад байгууллагатай хэрхэн уялдаж ажиллах талаарх зохицуулалтыг тусгаагүй байна.
8.	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төслийн 8.2 дахь хэсэгт заасан аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвийн зарим чиг үүрэг 8.4 дэх хэсэгт заасан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн чиг үүрэгтэй давхардаж байгааг анхаарах нь зүйтэй.
9.	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Хуулийн төслийн 11.1 дэх хэсэгт олон нийтийн оролцооны талаарх 4 заалтад төрийн байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран гүйцэтгэхээр тусгасан байна.
10.	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд татвар болон бусад төрлийн төлбөр, хураамж тогтоосон зохицуулалт тусгагдаагүй байна.
11.	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй байна.
12.	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Хуулийн төсөлд Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй байна.
13.	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөлд хүйсийн ялгавартай байдал бий болгосон зүйл, заалт тусгагдаагүй байна.

14.	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна.
15.	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тогтоогдоогүй болно.
16.	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг 17 дугаар зүйлд заахдаа 17.1 дэх хэсэгт “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага ногдуулна.” гэж, 17.2 дахь хэсэгт “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж тус тус заажээ. Мөн дээрх харилцааг тусгасантай холбогдуулан Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай дагалдах хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилго.

Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай, Эрүүл ахуйн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Дархлаажуулалтын тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай, Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай, Боловсролын тухай, Хүнсний тухай хууль болон холбогдох бусад хууль, хууль тогтоомжийн актад нийцсэн эсэхийг шалгасан болно.

#### **Тав. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал**

Хуулийн төсөлд дэвшүүлсэн зорилт бүрийн хүрээнд хамаарах зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг үнэлсэн. Тухайлбал, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүргийг тодорхойлох зорилтын хүрээнд Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газар, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхтэй холбогдох зохицуулалтыг, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилтын хүрээнд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх байгууллагын тогтолцоо, чиг үүрэгтэй холбогдох зохицуулалтыг

сонгон авч, хуулийн төслийн зорилтод хүрэх үр нөлөөг үнэлж, дүгнэхэд хуулийн төслийн зорилтыг нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах хүрээгээр хязгаарласан байна.

Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах асуудал нь нийгмийн бүх салбарын үйл ажиллагаанд хамааралтай тул зөвхөн эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг дэлгэрэнгүй зааж, төрийн бусад байгууллагын чиг үүргийг тодорхойлоогүй нь зарим талаар анхдагч хуулийн төслийн тухайд зөв сонголт болсон, цаашид энэхүү хуулийг хэрэгжүүлэх явцад дээрх орхигдсон асуудлыг оруулах боломжтой гэж үзлээ.

Төслийн ойлгомжтой байдлыг үнэлэхдээ хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх, Хууль тогтоомжийн тухай хууль болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгасан. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр, 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг дүгнэхэд энэ төрлийн зөрчил тогтоогдоогүй болно.

Төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу тодруулах шаардлагатай 16 төрлийн асуулгаас 13 нь шаардлагыг хангасан байна.

### **5.1. Зөвлөмж**

Хуулийн төслийн үр нөлөөг тооцох үнэлгээний үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна:

1. Хуулийн төсөлд нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн холбогдох төрийн байгууллагатай хэрхэн харилцах, мэдээлэл авах, солилцох, хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн асуудлаар хамтарсан судалгаа, шинжилгээ хийх зэрэг асуудлаар тодорхой зохицуулалт ороогүй байна. Иймд агаарын чанар, хөрс, усны бохирдол, байгаль орчинд хортой нөлөөлөх уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх аюултай хог хаягдал, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэндийн боловсрол, авто замын осол гэмтэл, архи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлт, худалдан борлуулах, хэрэглээ гэх мэт хүн амын эрүүл мэнд, амьдралын чанарт шууд нөлөөлөх хүчин зүйл, түүнчлэн эдгээр асуудал, чиг үүргийг хариуцдаг, үйл ажиллагаа нь шууд болон шууд бус байдлаар нийгмийн эрүүл мэндэд хамаарах байгууллагатай харилцах зэрэг асуудлаар зохицуулалтыг нэмж оруулах;
2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэг хэсэг болох нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тусламж, үйлчилгээ болон эрүүл мэндийг дэмжих,

хамгаалах тусламж, үйлчилгээгээр хязгаарлаж төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, бүрэн эрхийг заасан нь нийгмийн эрүүл, мэндийн тусламж үйлчилгээ авах эрхийг хангах хуулийн зорилтыг бүрэн хангаж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрх нь зөвхөн ноцтой байдлын үеийн тусламж, үйлчилгээгээр хязгаарлагдахгүй тул төслийн 5.3 дахь хэсэгт хүн амын эрүүл мэндийн байдалд нөлөөлөх хүчин зүйлийг судлах, хянах, төслийн 8 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж ямар чиг үүрэгтэйгээр, хэрхэн ажиллах зэргийг хуулийн төсөлд тодорхой тусгах;

3. Хуулийн төслийн 7.1 дэх хэсэгт “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төв байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн нэгж, алба, аж ахуйн нэгж. байгууллага үзүүлнэ.” гэж, төслийн 8.1 дэх хэсэгт нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төв байгууллагын чиг үүргийг заасан боловч эрүүл мэндийн бусад байгууллагуудтай хэрхэн уялдаж ажиллах талаарх зохицуулалт тусгагдаагүй;
4. Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх төвийн чиг үүргийг нийгмийн эрүүл мэндийн төвийн чиг үүрэгтэй давхардуулан зохицуулсныг дахин нягтлах;
5. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл нь анхдагч хуулийн хувьд хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх холбогдох дүрэм, журмыг шинээр боловсруулж батлуулах, бүх шатны Засаг дарга, иргэн, олон нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлэх тул удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг тусгасан “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулах;
6. Хуулийн төслийн 8.7 дахь хэсэгт нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын бүтэц, дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заажээ. Энэ заалтад бүх түвшинд ажиллаж байгаа нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудын чиг үүргийг тодорхой зааж оруулахыг зөвлөмж болгож байна.

## **5.2. Дүгнэлт**

Хуулийн төсөлд эрүүл мэндийн салбарын чиг үүргээс гадна бусад салбарын нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой чиг үүргийг тусгах нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүргийг тодорхойлсноор хуулийн зорилтыг бүрэн хангана. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг “амьд явах эрхтэй”, 2 дахь хэсэгт “эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах

эрхтэй”, 6 дахь хэсэгт “эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө төр хариуцна.” гэж заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх хангагдах баталгаа бүрдэнэ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлд нийцэж байгаа бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын хуулийн төсөл боловсруулахад тавих нийтлэг шаардлагыг бүрэн хангаж байна гэж дүгнэлээ.

### **5.3. Баримтжуулалт**

#### Монгол Улсын хууль:

1. Монгол Улсын Үндсэн хууль /1992/
2. Агаарын тухай хууль /2012/
3. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /2000/
4. Бага, дунд боловсролын тухай хууль /2002/
5. Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995/
6. Боловсролын тухай хууль /2002/
7. Дархлаажуулалтын тухай хууль /2000/
8. Донорын тухай хууль /2018/
9. Захиргааны ерөнхий хууль /2016/
10. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2016/
11. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль /2020/
12. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /2002/
13. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль /1993/
14. Монгол улсын Их Хурлын тухай хууль /2020/ Эрүүл мэндийн тухай хууль /2011/
15. Онцгой албан татварын тухай хууль /2006/
16. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль /2013/
17. Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль /2018/
18. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль /2008/
19. Тамхины хяналтын тухай хууль /2005/
20. Усны тухай хууль /2012/
21. Хог хаягдлын тухай хууль /2017/
22. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль /2008/
23. Хүнсний тухай хууль /2012/
24. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль /2012/

25. Хүний дархлал хомстолын вирусын халдвар, дархлалын олдмол хомстолоос сэргийлэх тухай хууль /2012/
26. Эрүүл ахуйн тухай хууль /2016/
27. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /2015/
28. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль /2016/

Улсын Их Хурлын тогтоол:

1. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого /Улсын Их Хурлын 2001 оны 81 дүгээр тогтоол/
2. Төрөөс эмийн талаар баримтлах бодлого /Улсын Их Хурлын 2002 оны 68 дугаар тогтоол/
3. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол/
4. “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай” /Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоол/

Засгийн газрын тогтоол:

1. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал
2. “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөр
3. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр
4. Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги
5. “Дархлаажуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай”
6. “Дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэх тухай”
7. “Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай”
8. “Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын зарим байгууллагын санхүүжилтийн тухай”

--- оОо ---